

# Судалгааны Тойм

№16 | WWW.FORUM.MN | БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ | СУДАЛГААНЫ САН | ВИДЕО

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБА ХААГЧ “БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДАЛ”-ЫН ҮЕД МӨРДӨЖ АЖИЛЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГГИЖ БУЙ БАЙДАЛ

### ТОВЧ ТАЙЛБАР

Дэлхий дахинд дэгдсэн коронавируст (COVID-19) цар тахлын халдвар манай улсад бүртгэгдсэнээр хүн амын амь нас, эрүүл мэндэд бодит аюул учирч, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хүрээнд хатуу болон хэсэгчилсэн “хөл хорио” тогтоох зэргээр ажиллаж буйтай холбогдуулан иргэдээс хүний эрх зөрчигдөж байгаа тухай гомдол ихээр гарах болсон.

Цахим мэдээллийн хэрэгслээр “цагдаагийн байгууллага, алба хаагчид эрх мэдлээ хэтрүүлж байна”, “иргэдийн амьдралын зайлшгүй хүндэтгэн үзвэл зохих шалтгааныг эс хайхран иргэдтэй зүй бус харьцаж байна”, “хүний эрхийг хууль бусаар хязгаарлаж байна” гэх агуулга бүхий мэдээлэл ч их гарах болсон нь энэ асуудлыг анхааран судлахад хүргэлээ.

### СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны баг “Цар тахалтай тэмцэх ажилд манай улс ямар хууль эрх зүйн актыг голлон мөрдөж байна вэ?”, “Цагдаагийн байгууллага, алба хаагч цар тахалтай тэмцэх ажилд ямар

Тиймээс судлаачид ННФ-ын захиалгаар “Цагдаагийн байгууллага, алба хаагч бүх нийтийн бэлэн байдлын үед мөрдөж ажиллах хууль, дүрэм журам, хэрэгжиж буй байдал” сэдвийн хүрээнд эрх зүйн дүн шинжилгээ хийж, Цагдаагийн байгууллага, алба хаагчид ямар хууль, дүрэм журмын хүрээнд иргэдийн тодорхой эрхийг хязгаарлаж ажилласан болох, иргэд цагдаагийн алба хаагчийн харилцаанд сөргөөр нөлөөлсөн гол хүчин зүйл юу байв зэрэг асуудлыг судалж, цаашид хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх санал, зөвлөмж боловсруулахыг зорьж энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны гол үр дүн, санал, зөвлөмжийг уншигчдад хүргэх зорилгоор энэхүү тоймыг бэлтгэлээ. Судалгааг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас бүрэн эхээр нь үзнэ үү.

оролцоотой оролцож байна вэ?”, “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед цагдаагийн алба хаагч хуульд зааснаас гадна нэмэлт эрх эдлэх үү?”, “Алба хаагчдын ажлын ачаалал хэр

их байна, үүрэг гүйцэтгэхэд энэ нь нөлөөлж байна уу?”, “Иргэдийн зарим эрхийг хязгаарлаж буй “хөл хорио”, “хорио цээрийн дэглэм”, “хязгаарлалтын дэглэм” гэж юу вэ, ямар хуулиар уг харилцааг зохицуулах вэ?” зэрэг судалгааны асуултад хариулт өгөх үүднээс холбогдох тоо

## СУДАЛГААНЫ ДҮН

Цар тахалтай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд Засгийн газар, Улсын онцгой комиссоос олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагийн зэрэгцээ вирусийн тархалтыг багасгах зорилгоор иргэдийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон нийт 5 шийдвэр гарган ажиллажээ. Эрх бүхий албан тушаалтан тодорхой шийдвэр гаргахдаа Гамшгаас хамгаалах тухай, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиуд (Цар тахлын тухай хууль гэх) болон салбарын бусад холбогдох хуулийг эрх зүйн үндэслэлээ болгож ажиллажээ.

Судалгаагаар дотоодод халдвар тархсан үе буюу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, иргэдийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох хүртэлх хугацаанд (2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр) иргэдийн хөдөлгөөнийг хязгаарласан үед төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт сул байлаа. Мөн цагдаагийн алба хаагч хязгаарлалтын дэглэмийг хэрхэн сахиулах талаар тухайлсан журам, зааваргүй байв.

2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 15 зүйл заалтаар эрх бүхий албан тушаалтанд цар тахлын үед ажиллах тодорхой дүрэм, журмуудыг батлах эрхийг хуулиар шилжүүлсэн боловч нэг журам л батлагдаж, бусад нь батлагдаагүй байлаа.

баримт, судалгаа шинжилгээ, хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрт дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, түүнийгээ санал асуулгын дүнгээр шинжлэн баталгаажуулах замаар судалгааг хийв.

Нийслэлийн засаг даргын “хязгаарлалтын дэглэм тогтоосон” шийдвэрүүдийн хууль, эрх зүйн үндэслэл оновчтой бус, хязгаарлалт тогтоосон зүйл заалт нь ойлгомжгүй, нөхцөл байдалтайгаа уялдаагүй, түүнчлэн уг шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчийн ажиллах дүрэм, журам батлагдан гараагүй байсны улмаас алба хаагчид өөрсдийн үзэмжээр шийдвэр гаргах, дарга удирдлагын аман шийдвэрээр ажиллах, зарим тодорхой тохиолдолд иргэд цагдаагийн алба хаагчийн дунд хэрүүл маргаан үүсгэж байсан нь судалгааны явцад тогтоогдсон.

“Хязгаарлалтын дэглэм” гэж засаг захиргаа, нутаг дэвсгэр, голомтын бүсэд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг зогсоох, иргэн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа болон эрхийг хязгаарлахыг ойлгох бөгөөд хязгаарлалтын дэглэм тогтоох, ажиллах журмыг Засгийн газар батлахаар хуульчилж өгчээ. Гэвч Засгийн газар болон эрх бүхий бусад албан тушаалтнаас гаргасан шийдвэрүүдэд “хөл хорионы дэглэм, хатуу хөл хорио” гэх зэрэг ямар хуульд заасан нь тодорхой бус, хуульд байхгүй нэр, томъёог тусгасан байх бөгөөд тэрхүү “хатуу хөл хорио”-гоор иргэдийн ямар эрхийг хэрхэн хязгаарлахыг зохицуулсан эрх зүйн зохицуулалтгүй байсан нь иргэдийн сэтгэл зүйг бухимдуулж, хүний эрх зөрчигдөхөд хүргэжээ.

Мөн судалгааны явцад цагдаагийн алба хаагчдын 64.5 хувь нь “иргэд хэл амаар

доромжилж цагдаагийн алба хаагчийн тавьсан шаардлагыг эсэргүүцэж байна”, 54.1 хувь буюу хоёр хүн тутмын нэг нь “амарч байгаа хугацаагаа өөрийн гэр бүлдээ зарцуулж чадахгүй байна...”

## ЗӨВЛӨМЖ

- Коронавируст халдварын аюулаас урьдчилан сэргийлэх, тархалтыг зогсоох үр дүнтэй арга хэмжээг тодорхойлох;
- Хүний эрхийг хөндөх хязгаарлалтын дэглэм шаардсан арга хэмжээг зөвхөн хуулиар тогтоох;
- Хориглосон, хязгаарласан дэг, горим тогтоож байгаа шийдвэрийг хуулийн шаардлагад нийцүүлэн гаргах;
- Хуульд заасан журмуудыг батлан гаргаж мөрдүүлэх. Тухайлбал, Цар тахлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1; 7.1.6; 7.1.17-д, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3; 8.1.4; 9 дүгээр зүйлийн 9.1; 9.2; 9.8; 9.9; 9.10; 9.11; 9.12-т, 16 дугаар зүйлийн 16.3-т болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасан журмуудыг тус тус батлан гаргах, мөрдөж ажиллах;
- Амьдралын зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаан, шийдэх арга замыг зохих журамд нарийвчлан тусгах;
- Хүний эрхийг хязгаарласан хязгаарлалтын дэглэмийг мөрдүүлэн сахиулах субъект, түүний үүрэг оролцоог тодорхой болгох;

гэх зэргээр хариулсан нь цагдаа-иргэдийн хоорондын харьцаа сайнгүй, цагдаагийн алба хаагчийн ажил, амралтын цагийг зүй ёсоор зохицуулж чадаагүй байгааг харуулж байна.

- Хууль, журмыг хэрэгжүүлэх аргачилсан зааврыг баталж мөрдүүлэх;
- Шинээр баталсан хууль, журмыг иргэдэд таниулах, сурталчлах, даган биелүүлэхийг уриалах ажлыг тухай бүр зохион байгуулах;
- Цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд хуулиар иргэн, аж ахуйн нэгжид хүлээлгэсэн үүргийг идэвхтэй сурталчилж ойлгуулах;
- Иргэний эрхийг хүндэтгэж хүнлэг, ёс зүйтэй харьцаж, хууль сахиулах;
- Гамшгаас хамгаалах тухай болон Цар тахлын тухай хуулийн зорилтын хүрээнд гарч байгаа эрх бүхий албан тушаалтны шийдвэр, уг хуулиудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхтэй холбоотой зүйл, заалтын хэрэгжилтийг хангах. Тухайлбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5, 49.6 дахь заалтын хэрэгжилтийг хангах;
- Цар тахлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 58 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж Цар тахлын тухай хуулийн хэрэгжилтийг сар бүр нээлттэй хэлэлцэх.

СУДЛААЧИД:  
Ж.ГАНБААТАР, Докторант  
Б.ДОРЖЗАЯА,  
Л.НЯМДАВАА, Докторант

СУДАЛГААНЫ ТОЙМ БОЛОВСРУУЛСАН:  
Б.ДОРЖЗАЯА

САНАЛ, ШҮҮМЖ ӨГСӨН:  
ННФ-ын Хуулийн хөтөлбөрийн менежер, Б.ХИШИГСАЙХАН



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Жамьян гүний гудамж-5/1,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240  
Утас: (976) 76113207

<http://www.forum.mn>  
<http://www.twitter.com/ForumOS>

<http://facebook/OpenSocietyForum>  
[http://www.instagram.com/open\\_society\\_forum](http://www.instagram.com/open_society_forum)